



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2005 оны 4 сарын 25 өдөр

Дугаар 160

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, "Биеийн тамир, спортын тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дугаар заалт, 10 дугаар зүйлийн 1.3 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын хорооны дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоох, байгууллагын дотоод журмыг шинэчлэн мөрдөх, үйл ажиллагааны стратеги, хэтийн чиглэлийг боловсруулан энэ оны 3 дугаар улиралд багтаан батлуулах ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Биеийн тамир, спортын хороо /Ж.Ганболд/-т даалгасугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2001 оны 09 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2005 оны
4-р сарын 25-ны өдрийн 160 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Нийслэлийн Биеийн тамир, спортын хороо /цаашид "Хороо" гэнэ/ нь Монгол Улсын нийслэл-Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, нийслэл хотын хэмжээнд биеийн тамир, спортын хүрээний асуудал, үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах асуудлыг эрхлэн зохион байгуулах төрийн захиргааны байгууллага-Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг мөн.

1.2 Хорооны үндсэн зорилго нь нийслэлийн хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх, эрүүл мэндийг бэхжүүлэх, иргэдэд эрүүл аж төрөх ёс, зан үйлийг төлөвшүүлж хэвшүүлэх, биеийн тамир, спортыг хөгжүүлэх, мэргэжлийн боловсон хүчний талаар баримтлах бодлого боловсруулж хэрэгжүүлэх, биеийн тамир, спортын санхүү, эдийн засаг, материаллаг баазын хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлэх, биеийн тамир, спортын барилга, байгууламжийн ашиглалтыг иргэдэд хүртэх хүртээмж, чанар, үр ашгийг сайжруулах, спортын шинжлэх ухааны сүүлийн үеийн ололтуудыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх, нийслэлийн тамирчдын амжилтыг тууштай дээшлүүлэх зэрэг биеийн тамир, спортын салбарын хөгжлийг зах зээлийн нийгэмд хангах орчин, нөхцөл бүрдүүлэхэд оршино.

1.3 Хороо нь үйл ажиллагаандаа Монгол улсын хууль, тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын тогтоол, шийдвэр, мөрийн хөтөлбөр болон энэхүү дүрмийг удирдлага болгон мөрдөж ажиллана.

1.4 Хороо нь тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг хэрэглэнэ. Өөрийн онцлогийг илэрхийлсэн онцлох тэмдэгтэй /эмблем/-тэй байна.

1.5 Хороо нь банкинд харилцах данстай байна.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт, бүтэц

2.1 "Биеийн тамир, спортын тухай" Монгол улсын хуулийн 10.3-т заасны дагуу Нийслэлийн Засаг дарга бүрэн эрхийнхээ хүрээнд нийслэлийн биеийн тамир, спортын хороог байгуулж, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц, албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолтыг баталж, Биеийн тамир, спортын улсын хороотой зөвшилцөн хорооны даргыг томилж, чөлөөлнө.

2.2. Хороо нь Нийслэлийн Засаг дарга, түүний орлогч, Тамгын газрын удирдлагын дор үйл ажиллагаагаа явуулж, тайлагнана.

2.3 Хорооны даргын дэргэд байгууллагын зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байх зөвлөл байна. Зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг хорооны дарга батална.

2.4 Хорооны дарга нь Нийслэлийн Засаг даргатай хууль тогтоомжид заасан зохих журмын дагуу үр дүнгийн гэрээ байгуулан ажлаа тайлагнана.

2.5. Хорооны дарга нь дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

2.5.1. Монгол улсын нийслэл -Улаанбаатар хотод биеийн тамир, спортыг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны бодлого, үзэл баримтлалын үзэл санааг амьдралд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

2.5.2 Хорооны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг удирдлага болгон ажиллах

2.5.3 Хороо болон түүний харьяа дүүргүүдийн Биеийн тамир, спортын хорооны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах

2.5.4 Батлагдсан цалингийн сан, төсөвтөө багтаан хорооны бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, өөрчлөлт хийх санал дэвшүүлэх

2.5.5 Хорооны гадаад дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх

2.5.6 Батлагдсан төсөв, өөрийн үйл ажиллагааны орлого, хандив, бусад эх үүсвэрийн орлогыг хууль, тогтоомжийн дагуу захиран зарцуулах

2.5.7 Өөрийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах асуудлаар тушаал гарган, биелэлтийг хангуулах

2.5.8 Монгол улсын хууль тогтоомж, Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр олгосон бусад бүрэн эрх.

Гурав. Хорооны ажлын чиг үүрэг

3.1 Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомж, төрийн бодлогыг нийслэл хотод хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3.2 Төрийн болон төрийн бус байгууллагууд, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх газар, хэрэгжүүлэгч агентлагуудтай хорооны зорилгыг хэрэгжүүлэх талаар нягт хамтран ажиллах;

3.3 Нийслэлийн хэмжээний биеийн тамир, спортын спартакиад, наадам, аварга шалгаруулах болон олон улсын уралдаан, тэмцээн, уулзалт, тоглолт, баяр цэнгүүн , өдөрлөг бусад арга хэмжээг удирдан зохион байгуулах;

3.4 Нийслэлийн биеийн тамир, спортын түүх, хөгжлийн асуудлаар мэдээллийн сан бий болгох, шинжлэх ухаан, онол, арга зүйн ном, сэтгүүл, сонин, зөвлөмж, аргачлал бэлтгэж хэвлүүлэх;

3.5 "Биеийн тамир, спортын тухай" Монгол улсын хуулийн 18 дугаар зүйлийн холбогдох заалтын дагуу Нийслэлийн Засаг даргын дэргэд оюутны болон өсвөр үеийн шигшээ багийг хуульд заасны дагуу бүрдүүлэн ажиллуулах журмыг боловсруулж батлуулан мөрдөх;

3.6 Биеийн тамир, спортын материаллаг баазын бэхжүүлэх, тоног төхөөрөмж, хувцас хэрэглэлийн хангамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих

3.7 Дотоод, гадаадын төрийн болон төрийн бус байгууллагууд, бизнесийн хүрээнийхэнтэй биеийн тамир, спортыг нийслэлд хөгжүүлэх чиглэлээр хамтран үр ашигтай ажиллах;

3.8 Биеийн тамир, спортын хөгжлийн асуудлаар нийслэлийн хэмжээний зөвлөлгөөн, семинар, эрдэм шинжилгээ, онол-практикийн хурал, зохион байгуулах, төрөл бүрийн сургалт явуулах;

3.9 Хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран эрүүл аж төрөх ёс, зан үйл, биеийн тамир, спортын асуудлаар мэдээлэл, сурталчилгааны бодлого боловсруулан хэрэгжүүлэх;

3.10 Дүүрэг, хороо, орон сууцны хороололын иргэд, албан байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтан ажиллагсдын дунд биеийн тамир, спортын ажлыг зохион байгуулах талаар арга зүйн зөвлөгөө өгч, мэргэжлийн удирдлагаар хангах;

3.11 Биеийн тамир, спортын хөгжлийг тодорхойлох үндсэн болон хавсарга үзүүлэлтүүдээр статистикийн тоо, баримт, тайлан мэдээг нэгтгэн боловсруулалт хийх;

3.12 Гадаад орны нийслэл болон ах дүүгийн харилцаатай бусад хотуудын биеийн тамир, спортын адил түвшний байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр байгуулах;

3.13 Нийслэлд спортын төрлүүдийг хөгжүүлэх бодлогын асуудлаар спортын холбоодтой хамтран ажиллах;

3.14 Хорооны албан хаагчдын мэргэжил, мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх, төрөл бүрийн сургалтад оролцуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

3.15 Хууль тогтоомжоор болон Нийслэлийн Засаг даргаас олгосон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх.

Дөрөв. Хорооны эрх

4.1 Нийслэлд биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого, үзэл баримтлал, хөтөлбөр, төсөл болон бусад чухал ач холбогдолтой асуудал боловсруулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг хангах

4.2 Нийслэл хотод биеийн тамир, спортын уралдаан, тэмцээн бэлтгэж, зохион байгуулах, санхүүжүүлэх, ивээн тэтгэх, түрүүлсэн буюу шагналт байранд шалгарсан байгууллага, баг, тамирчид, дасгалжуулагч, шүүгчдэд шагнал,

урамшил олгох асуудлаар дүрэм, журам, заавар, хөтөлбөр, арга зүйн удирдамж, гарын авлага зэргийг боловсруулж, баталж мөрдүүлэх

4.3 Харъяа байгууллагыг байгуулах өөрчлөх, татан буулгах асуудлыг зохих журмын дагуу нийслэлийн Засаг даргын тамгын газарт оруулж шийдвэрлүүлэх, тэдгээрийн удирдах албан тушаалтныг томилоход санал өгөх

4.4 Нийслэлийн Засаг даргаас зөвшөөрсөн бүтэц, орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилж, чөлөөлөх

4.5 Хүн амын дунд зохиох нийтийн биеийн тамир,спортын сургалтын хөтөлбөр, нэгдсэн ангилал, бусад нормативыг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж саналаа өгөх

4.6 Эрхэлсэн ажлын холбогдолтой мэдээ материалыг холбогдох газар, дүүргүүдийн Засаг даргын тамгын газар, биеийн тамир,спортын хороо бусад байгууллагаас гаргуулан авах

4.7 Хорооны эрх хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дэргэдээ орон тооны бус комисс, зөвлөлийг байгуулж ажиллах, тодорхой асуудал боловсруулахад зохих мэргэжлийн хүмүүсийг холбогдох байгууллагатай нь зөвшөөрөлцсөний үндсэн дээр урьж оролцуулах

4.8 Спортын арга хэмжээний төсвийг батлуулж хуваарилан олгох, ашиглалт зарцуулалтанд хяналт тавих

4.9 Биеийн тамир,спортыг хөгжүүлэх үйлсэд тодорхой хувь нэмэр оруулсан, спортын гарамгай амжилт гаргасан хүмүүсийг Монгол улсын алдар цол, төрийн дээд болон Засгийн газар, нийслэлийн Засаг даргын шагналаар шагнуулах саналыг зохих журмын дагуу эрх бүхий байгууллагад оруулах, тус хорооны шагналаар шагнах

4.10 Тамирчид, шүүгчид, дасгалжуулагчид, биеийн тамир,спортын ажилтнуудад хуулийн хүрээнд заасан хариуцлага тооцож, сахилгын арга хэмжээ авах

Тав. Хүлээлгэх хариуцлага

5.1 Хорооны дарга ажилтнуудын нь бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ болон энэхүү дүрмээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Зургаа Бусад зүйл

6.1 Энэхүү дүрмэнд Засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

6.2 Энэхүү дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр зохих эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

-----oOo-----

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ НИЙСЛЭЛИЙН
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН
ХОРООНЫ БҮТЦИЙН СХЕМ

